

Хөгжимдөх үеийн түгшүүрийн судалгааны хүрээ, үзэл баримтлал

Аюурын Ууганзаяа 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,

Улаанбаатар, Монгол Улс

✉ uuganzayaayur@gmail.com

Хураангуй: Хөгжимдөх үеийн түгшүүр (Music Performance Anxiety MPA) нь мэргэжлийн болон суралцагч хөгжимчдийн дунд өргөн тархсан, сэтгэл зүй, уран бүтээлийн гүйцэтгэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг цогц үзэгдэл юм. Энэхүү өгүүллийн зорилго нь МРА-ийн онолын үндэс, судалгааны хөгжил, гол үзэл баримтлалуудыг тодорхойлон шинжлэхэд оршино. Судалгаанд онолын тойм болон харьцуулсан шинжилгээний аргыг ашиглаж, хөгжимдөх үеийн сэтгэл судлалын чиглэлд хийгдсэн олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нэгтгэн авч үзэв. Судалгаанаас үзэхэд МРА нь танин мэдэхүйн, физиологийн, зан үйлийн болон нийгэм-соёлын хүчин зүйлсийн харилцан нөлөөллөөр илэрдэг болох нь тодорхой байна. Бид Уилсон, Кенни, Папагеорги, Слобода-Лемэн нарын онолын загваруудыг харьцуулан шинжилсний үндсэнд МРА-ийн судалгааны анхаарлын төвлөрөл хувь хүний зан чанараас нийгэм-боловсролын орчин, улмаар нейробиологи¹-ийн болон интервенц²-ийн чиглэл рүү шилжиж ирсэн хандлага хэмээн тодорхойлогдож байна.

Орчин үеийн судалгаанд хөгжимдөх үеийн түгшүүрийг зөвхөн хувь хүний сэтгэл зүйн шинжээр тайлбарлахаас илүүтэйгээр хөгжимдөх орчин, боловсролын үйл явц, хөгжмийн сургалтын арга зүйтэй уялдуулан авч үзэх хандлага нэмэгдэж байна. Ялангуяа хөгжмийн боловсролын орчин дахь үнэлгээний тогтолцоо, хөгжимдөх туршлага, багш-сурагчийн харилцаа, илэрхийллийн соёл зэрэг хүчин зүйлс МРА үүсэх болон илрэхэд чухал нөлөө үзүүлдэг болохыг судалгаанууд харуулж байна (Papageorgi, Hallam & Welch 2007; Kenny 2011).

Түлхүүр үгс: хөгжимдөх үеийн түгшүүр, сэтгэл зүй, хөгжимдлөг, хөгжмийн боловсрол, орчин

¹ **Нейробиологи** – тархи болон мэдрэлийн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааг судалдаг шинжлэх ухааны салбар

² **Интервенц** – тодорхой асуудлыг шийдвэрлэх, эсвэл нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлдэг арга хэмжээ, нөлөөлөл

Music Performance Anxiety: Research Scope and Conceptual Framework

Uuganzaya Ayur 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

✉ uuganzayaayur@gmail.com

Abstract: Music Performance Anxiety (hereafter MPA) is a complex phenomenon widely prevalent among professional and student musicians, exerting a significant influence on psychological well-being and artistic performance. The purpose of this article is to identify and analyze the theoretical foundations, research developments, and key conceptual frameworks of MPA. The study employed theoretical review and comparative analysis methods, synthesizing international scholarly works in the field of performance psychology. The findings indicate that MPA manifests through the interplay of cognitive, physiological, behavioral, and sociocultural factors. Through comparative analysis of theoretical models proposed by Wilson, Kenny, Papageorgi, and Sloboda-Lehmann, a clear developmental trajectory was identified, wherein the research focus has shifted from individual personality traits toward socio-educational environments, and subsequently toward neuroscientific and intervention-based approaches.

Contemporary research increasingly tends to examine MPA not solely through the lens of individual psychological characteristics, but in connection with performance environments, educational processes, and music pedagogical methods. In particular, research demonstrates that factors such as assessment systems within music education settings, performance experience, teacher-student relationships, and expressive culture play a significant role in the emergence and manifestation of MPA (Papageorgi, Hallam & Welch, 2007; Kenny, 2011).

Keywords: *music performance anxiety, psychology, performance, music education, environment*

Оршил

Олон нийтийн өмнө хөгжимдөх, дуулах, удирдах зэрэг нөхцөлд айдас, сөрөг бодол, өөрийгөө үнэлэх үнэлэмжийн бууралт, мөн зүрхний цохилт хурдсах, гар чичрэх, амьсгал түргэсэх зэрэг физиологийн хариу урвал илэрдэг онцлогтой. Ийм шинж тэмдгүүд нь тухайн уран бүтээлчийн гүйцэтгэлийн чанарт нөлөөлж, эзэмшсэн ур чадвараа бүрэн илэрхийлэх боломжийг хязгаарлах тохиолдол түгээмэл байдаг.

Түгшүүр нь хөгжимдөхийн өмнө, үеэр болон дараа илэрч болох бөгөөд зарим тохиолдолд хөгжимчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг гэж судлаачид тэмдэглэжээ (Kenny 2011).

Хөгжимдөх үеийн түгшүүрийн талаарх судалгаа XX зууны дунд үеэс эхлэн эрчимтэй хөгжсөн бөгөөд анхны судалгаанууд тайзны сандрал (stage fright) болон уран сайхны илэрхийллийн хүрээнд хийгдэж байв. 1960–1970-аад оноос эхлэн

сэтгэл судлалын онолын чиглэлүүдтэй уялдуулан илүү системтэй судлах болсон бөгөөд ялангуяа танин мэдэхүйн сэтгэл судлалын хөгжилтэй холбоотойгоор нөхцөл байдлыг хөгжимчин хэрхэн үнэлж, тайлбарлаж байгаатай холбон судлах хандлага өргөжсөн. Үүний зэрэгцээ Music Performance Anxiety (цаашид МРА гэх) нь ерөнхий түгшүүрийн эмгэг, нийгмийн түгшүүрийн эмгэг зэрэг ойлголттой тодорхой хэмжээнд огтлолцдог боловч хөгжимдөх онцлог, уран бүтээлийн орчин, мэргэжлийн үнэлгээний нөхцөлтэй нягт холбоотой байдгаараа ялгаатай гэж үздэг. Сүүлийн жилүүдэд МРА нь зөвхөн тоглолтын үр дүнд нөлөөлөхөөс гадна хөгжимчдийн мэргэжлийн замнал, уран бүтээлийн өөрийгөө илэрхийлэх чадвар, сэтгэл ханамжид урт хугацааны нөлөө үзүүлэх боломжтойг судалгаанууд онцолж байна. Ялангуяа хөгжмийн боловсролын эхэн шатанд илэрсэн түгшүүр нь цаг хугацааны явцад архаг шинжтэй болж, тайзнаас зайлсхийх, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байдаг. Иймээс МРА-г зөвхөн клиник сэтгэл судлалын хүрээнд бус, хөгжмийн боловсрол, хөгжимдөх орчин, хувь хүний хөгжлийн онцлог болон нийгэм-соёлын хүчин зүйлстэй уялдуулан судлах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэ хүрээнд МРА-ийн онолын үндэс, тайлбарлах загварууд, судалгааны хөгжлийг нэгтгэн авч үзэх нь уг илрэлийг илүү цогц байдлаар ойлгоход чухал ач холбогдолтой юм.

Судалгааны зорилго: Энэхүү өгүүллийн зорилго нь хөгжимдөх үеийн түгшүүрийн судалгааны хүрээ, онолын үндэс, гол үзэл баримтлалуудыг тодорхойлон шинжлэхэд оршино.

Судалгааны зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. Хөгжимдөх үеийн түгшүүрийн талаарх судалгааны онолын үндсийг тодорхойлох
2. МРА-ийн талаарх олон улсын судалгааны чиг хандлагыг тоймлон шинжлэх
3. МРА-ийн танин мэдэхүйн, физиологийн болон зан үйлийн хүчин зүйлсийг тайлбарлах

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь онолын судалгааны шинжтэй бөгөөд онолын тойм (literature review), агуулгын шинжилгээ (content analysis), харьцуулсан шинжилгээ (comparative analysis)-ний аргуудыг ашиглав. Онолын тоймоор хөгжимдөх үеийн түгшүүрийн талаарх үндсэн үзэл баримтлал, онолын хөгжлийг авч үзсэн. Агуулгын шинжилгээгээр судалгаануудад дурдагдсан МРА-ийн шалтгаан, илрэл, нөлөөлөх хүчин зүйлс болон тайлбарлах загваруудын нийтлэг болон ялгаатай шинжүүдийг ангилан судлав. Харьцуулсан шинжилгээгээр Гленн Уилсон (Glenn Wilson), Диана Кенни (Diana Kenny), Иоанна Папагеорги (Ioanna Papageorgi), Жон Слобода (John Sloboda), Андреас Лемэн (Andreas Lehmann) нарын онолын загваруудын үндсэн үзэл баримтлал, хувь нэмэр, хязгаарлалтыг харьцуулан үнэлэв.

Эх сурвалжийг сонгохдоо 1980–2024 оны хооронд хэвлэгдсэн, олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээлүүдээс МРА-ийн онолын үндэс, хөгжлийн чиг хандлага болон интервенцийн судалгаанд өргөн эшлэгддэг бүтээлүүдийг хамруулав.

Судалгааны үр дүн

Анхны судалгаануудад МРА-г голдуу гүйцэтгэлийн нөхцөлд үүсдэг айдас, зан чанарын түгшүүрийн үүднээс авч үздэг байсан бол Диана Кенни (Diana Kenny 2011)-ийн биопсихосоциал загвар болон Иоанна Папагеорги (Ioanna Parageorgi) нарын (2007) нийгэм-боловсролын загвар судалгааны анхаарлыг боловсролын орчин, багш-сурагчийн харилцаа, тайзны туршлага, үнэлгээний тогтолцоо руу өргөжүүлсэн нь мэдэгдэхүйц ахиц болсон гэж үзэж болохоор байна. Слобода, Лемэн нарын дасан зохицлын загвар МРА-г гүйцэтгэлд эерэг болон сөрөг нөлөө хоёуланг нь үзүүлэх боломжтой олон талт үзэгдэл гэж тайлбарласан нь интервенцийн судалгааны чухал тулгуур болсныг харж болно.

Интервенцийн чиглэлд 1982–2024 оны хооронд нийтлэгдсэн судалгаануудыг нэгтгэн харахад Танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ (Cognitive Behavioral Therapy)³, Хүлээн зөвшөөрөх ба амлалтат эмчилгээ (Acceptance and Commitment Therapy)⁴, Mindfulness⁵, Виртуал бодит байдал (Virtual Reality)⁶ зэрэг аргуудын үр нөлөө баталгаажсан байгааг ажиглаж болно. Нейровизуалчлал (fMRI), биомаркер, VR зэрэг орчин үеийн арга зүй өмнөх асуулгын арга зүйтэй харьцуулахад судалгааны найдвартай байдлыг дээшлүүлсэн нь чухал дэвшил болсон гэж дүгнэж болох юм.

МРА-г шинжлэх ухааны үүднээс судлах анхны оролдлого 1980-аад оноос эхэлсэн. Салмон (Salmon 1990) МРА-г “олон нийтийн өмнө хөгжимдөх чадварыг алдагдуулдаг сандрал, мэдрэмж” гэж тодорхойлсон бол Фишбейн (Fishbein et al. 1988) нар хөгжимчдийн 24% нь тайзны сандрал илэрдэг болохыг нотолжээ.

МРА-г тайлбарлах хэд хэдэн онолын хандлага хөгжсөн байна. Тухайлбал,

- Бек (Beck 1979)-ийн танин мэдэхүйн онолоор МРА нь сөрөг бодол, гажуудсан схемүүдийн үр дүн;
- Кларк, Уэллс (Clark & Wells 1995)-ийн нийгмийн айдсын загвараар бусдын үнэлгээнд өртөх айдсын тусгай хэлбэр;
- Зан үйлийн онолоор өмнөх сөрөг туршлагаас үүссэн нөхцөлт айдас;
- Перфекционизмын онолоор хэт өндөр стандартаас үүдэлтэй гэж тус тус тайлбарладаг.

2000-аад оноос эхлэн МРА-г танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйлийн цогц үзэгдэл гэж үзэх хандлага хөгжиж, орчин үеийн судалгаанд тархалт нь 16–60% хооронд хэлбэлздэг болохыг тогтоожээ (Fernholz et al. 2019). Түүнчлэн Херман, Кларк (Herman & Clark 2023) нар МРА-г зайлсхийх ёстой эмгэг гэж үзэх уламжлалт хандлагыг шүүмжилж, гүйцэтгэлийн нөхцөлд илэрдэг **хэвийн бөгөөд байгалийн хариу урвал** гэж дахин тодорхойлсноор судалгаанд шинэ чиг хандлага нээжээ.

³ СБТ - Сөрөг бодол, итгэл үнэмшил болон зан үйлийн хэв маягийг өөрчлөхөд чиглэсэн сэтгэл заслын арга

⁴ АСТ - Түгшүүр, сөрөг мэдрэмжийг дарах бус хүлээн зөвшөөрч, хувь хүний үнэт зүйлд нийцсэн үйлдэл хийхэд чиглэсэн сэтгэл заслын арга.

⁵ Анхаарал төвлөрүүлэх бясалгал буюу одоо болж буй үйл явдлыг шүүмжлэлгүйгээр ухамсарлан ажиглах сэтгэл зүйн арга

⁶ VR - Компьютерийн тусламжтайгаар бодит орчныг дуурайлган бүтээсэн орчинд хэрэглэгчийг оруулж туршлага олгодог технологи

Бид судалгаандаа МРА-ийн онол, үзэл баримтлалын чиглэлээр хийсэн дараах судалгаа, хандлагуудыг авч үзсэнийг харж болно.

Хүснэгт 1. МРА-ийн судалгааны үндсэн загвар, онолын хандлагуудын харьцуулалт

Судлаачид	Он	Онолын хандлага / Загвар	Гол хувь нэмэр	Хязгаарлалт / Шүүмж
Йерксен, Додсон (Yerkes & Dodson)	1908	Урвуу U хэлбэрийн гүйцэтгэлийн загвар; сэрэлт ба гүйцэтгэлийн хамаарал	Дунд зэргийн сэрэл гүйцэтгэлд оновчтой нөлөөтэй болохыг нотолсон; МРА-ийн бүх онолын загварын үндсэн суурь болсон	Хөгжмийн гүйцэтгэлд тусгайлан хэрэглэгдээгүй; хүчин зүйлсийн нарийн ялгааг тайлбарлахад хязгаарлагдмал
Гленн Уилсон (Wilson)	1973–2002	Танин мэдэхүйн үнэлгээний загвар; Бекийн (1979) схемийн онол болон Айзенкийн бүтцийн онол дээр суурилсан; Йерксен-Додсоны загварыг МРА-д тохируулсан	МРА-г зан чанар, нөхцөл байдал, ур чадварын гурван хүчин зүйлийн харилцан үйлчлэл гэж анх системтэй тодорхойлсон; нейротицизмийн нөлөөг нотолсон	Нийгэм-соёлын болон боловсролын орчны нөлөөг хангалтгүй тусгасан
Стептоу (Steptoe)	1987–2001	Танин мэдэхүйн сөрөг үнэлгээний загвар; тайзны айдас ба МРА-ийн харьцуулсан шинжилгээ	Тайзны айдас ба МРА-ийн ялгааг анх системтэй тодорхойлсон; сөрөг танин мэдэхүйн үнэлгээний гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг нотолсон	Биологийн болон хөгжлийн хүчин зүйлсийг хангалтгүй тусгасан; загварын эмпирик баталгаажуулалт хязгаарлагдмал
Диана Кенни (Kenny)	2004–2016	Хавсаргалтын онол (Bowlby); Барлоугийн (2000) гурвалсан эмзэг байдлын загварыг МРА-д тохируулсан; DSM оношилгоотой уялдуулсан	Эртний эцэг эхтэй харилцааны нөлөөг нотолсон; КМРАI хэмжүүр боловсруулсан (2004, 2009); МРА-г нийгмийн айдсын эмгэгтэй харьцуулан шинжилсэн	Агшин зуурын нөхцөл байдлын хүчин зүйлийг харьцангуй дутуу авч үзсэн; хувь хүний хөгжлийн тасралтгүй байдалд илүү төвлөрсөн

Судлаачид	Он	Онолын хандлага / Загвар	Гол хувь нэмэр	Хязгаарлалт / Шүүмж
Барлоу (Barlow)	2000–2002	Гурвалсан эмзэг байдлын загвар: биологийн, ерөнхий сэтгэл зүйн, тусгай сэтгэл зүйн эмзэг байдлын харилцан нөлөөлөл	Биологи, танин мэдэхүй, нөхцөлжилтийн харилцан нөлөөллийг нэгтгэсэн; Кеннийн КМРАI загварын шууд онолын суурь болсон; орчин үеийн бүх МРА интервенцийн онолын үндэс	МРА-д тусгайлан боловсруулагдаагүй; хөгжмийн гүйцэтгэлийн өвөрмөц нөхцөлийг хангалтгүй тусгасан
Папагеорги, Халлам, Уэлч (Papageorgi, Hallam, Welch)	2007	Нийгэм-боловсролын цогц загвар; гурван давхаргат бүтэц (дотоод, нөхцөл байдал, боловсрол); генетик болон орчны харилцан нөлөөлөл	МРА-г нийгмийн орчин ба хөгжмийн боловсролын тогтолцоотой нягт уялдуулсан анхны системтэй загвар; хүйс, нас, хувь хүний онцлогийн нөлөөг тусгасан	Эмпирик баталгаажуулалт хязгаарлагдмал; загварын хэрэглээ ихэвчлэн боловсролын контекстэд голлосон
Слобода, Лемэн (Sloboda, Lehmann)	1997–2010	Мэргэжлийн хөгжил ба дасан зохицлын загвар; гүйцэтгэлийн чанар дахь МРА-ийн давхар үүрэг; Йерксен-Додсоны загвартай уялдсан	МРА нь тодорхой нөхцөлд гүйцэтгэлийг дэмждэгийг нотолсон; дадлагын явцад дасан зохицох стратегийг анх судалсан	Клиникийн оношилгооны хэлбэртэй нэгтгэх боломж хязгаарлагдмал; судалгааны хамрах хүрээ мэргэжлийн хөгжимчдөд голчлон чиглэсэн
Сүүлийн үеийн судалгаа (Dietrich, Chang, Chong, Bonneville-Roussy, Herman, Clark нар)	2015–2024	Нейробиологи (fMRI); Mindfulness интервенц (RCT); Виртуаль бодит байдал (VR); Ковид-19-ийн нөлөө; МРА-г хэвийн үзэгдэл болгон дахин тодорхойлох чиглэл	Тархины anterior cingulate cortex болон amygdala-ийн үүрэг тогтоосон; mindfulness болон VR хөтөлбөрийн үр нөлөөг баталгаажуулсан; цахим гүйцэтгэлийн МРА нэмэгдсэнийг нотолсон; МРА-г эмгэг бус хэвийн хариу урвал гэж тайлбарлах шинэ чиглэл нээсэн	Олон судалгааны дээж жижиг; арга зүйн нэгдмэл байдал хангалтгүй; нийтлэг мета-шинжилгээ дутагдалтай

Дээрх судалгааны хандлагуудыг харьцуулан авч үзэхэд дараах зүй тогтол ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, судалгааны анхаарлын төвлөрлийн хувьд Уилсоны загвар хувь хүний зан чанар, Кеннийн загвар хөгжлийн болон клиникийн хүчин зүйл, Папагеорги (Parageorgi) нарын загвар боловсролын орчин, Слобода-Лемэний загвар дасан зохицлын механизмыг тус тус онцолдог бол орчин үеийн судалгаа эдгээр хүчин зүйлсийг нэгтгэн авч үзэх цогц хандлагыг баримтлах болсон.

Хоёрдугаарт, тодорхойлолтын хувьд анхны судалгаанууд МРА-г голдуу нийгмийн айдсын нэг хэлбэр буюу гүйцэтгэлтэй холбоотой нөхцөл байдлын айдас гэж тодорхойлж байсан бол орчин үеийн судалгаанд динамик шинжтэй сэтгэл зүйн үзэгдэл гэж тайлбарлах хандлага давамгайлж байна. Энэ чиглэлд Херман, Кларк (Herman & Clark 2023) нарын МРА-г эмгэг бус хэвийн хариу урвал гэж дахин тодорхойлсон нь онцлох үзэл баримтлал болжээ.

Гуравдугаарт, арга зүйн хувьд эрт үеийн судалгаанд асуулгын аргыг голчлон ашиглаж байсан бол сүүлийн арав гаруй жилд тархины үйл ажиллагааг зургаар харуулах нейровизуалчлал (fMRI), биологийн хариу урвалыг хэмждэг биомаркер, гүйцэтгэлийн нөхцөлийг дуурайлган бүтээдэг виртуал бодит байдал (VR) зэрэг дэвшилтэт арга зүй өргөн нэвтэрч, судалгааны найдвартай байдал мэдэгдэхүйц дээшилсэн байна.

Хөгжимдөх үеийн түгшүүр (МРА) нь олон нийтийн өмнө хөгжмийн гүйцэтгэл үзүүлэх явцад илэрдэг сэтгэл зүйн түгшүүрийн онцгой хэлбэр бөгөөд танин мэдэхүйн, физиологийн болон зан үйлийн илрэлүүдээр тодорхойлогддог (Kenny 2011). Олон улсын судалгаагаар МРА-ийн тархалт мэргэжлийн болон суралцагч хөгжимчдийн дунд 16.5%-аас 60% хүртэл хэлбэлздэг бөгөөд энэхүү ялгаа нь судалгаанд хамрагдсан оролцогчдын нас, хүйс, хөгжмийн төрөл, соёлын орчин болон ашигласан хэмжих хэрэгслээс шалтгаалдаг болохыг Фернхолц болон бусад эрдэмтэд (Fernholz et al. 2019) тогтоосон байна. Папагеорги, Грич Уэлч (Parageorgi, Creech, Welch 2013)-ийн Их Британид хийсэн судалгаагаар хөгжмийн их, дээд сургуулийн оюутнуудын 40–70% нь тайзан дээр гүйцэтгэх үед тодорхой түвшний түгшүүр мэдэрдэг бөгөөд перфекционизм, өөртөө хэт өндөр шаардлага тавих, багш болон үзэгчдийн үнэлгээнд хэт анхаарах нь МРА-ийн гол урьдчилсан нөхцөл болдгийг нотолжээ. Ёоши нарын (Yoshie et al. 2019) судалгаагаар 8–12 насны хүүхдүүдийн 15–50% нь олон нийтийн өмнө тоглох үед түгшүүр мэдэрдэг бөгөөд нас ахих тусам гүйцэтгэлийн түгшүүрийн эрчим нэмэгдэх хандлагатай болохыг тогтоосон нь МРА хөгжмийн боловсролын эхэн шатаас илэрч, цаг хугацааны явцад архаг шинж олж болзошгүйг харуулж байна. Кенни (Kenny 2011)-ийн интеграцчилсан загвараар МРА нь зөвхөн тайзны нөхцөлтэй холбоотой нөхцөл байдлын айдас бус, харин хувь хүний хөгжлийн эрт үеийн туршлага, хавсралтын хэв маяг болон танин мэдэхүйн үнэлгээний харилцан үйлчлэлээр бүрэлдсэн олон хүчин зүйлт сэтгэл зүйн үзэгдэл болохыг онцолсон байна. Дээрх судалгааны дүнгүүд нь МРА-г зөвхөн тайзны сандрал гэх хялбаршуулсан ойлголтоор бус, харин хувь хүний сэтгэл зүйн хөгжил, хөгжмийн боловсролын орчин болон нийгэм-соёлын хүчин зүйлсийн нийлбэр үр дүн гэж авч үзэх онолын болон практик шаардлагыг нотолж байна.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаанд хөгжимдөх үеийн түгшүүр (МРА)-ийн онолын хөгжлийг авч үзэхэд уг үзэгдлийг тайлбарлах хандлага нь цаг хугацааны явцад агуулгын хувьд гүнзгийрч, өргөжсөн нь ажиглагдана. Эрт үеийн судалгаанд МРА-г гүйцэтгэлийн нөхцөлд үүсэх айдас, хувь хүний зан чанарт суурилсан түгшүүрийн хэлбэрээр тайлбарлаж байсан бол орчин үеийн судалгаанд олон хүчин зүйлт, динамик шинжтэй цогц үзэгдэл болгон авч үзэх хандлага давамгайлж байна.

Гэсэн хэдий ч онолын хандлагуудыг харьцуулан үзэхэд тэдгээр нь МРА-ийн тодорхой талыг онцолдог боловч цогцоор нь тайлбарлахад хязгаарлагдмал хэвээр байна. Зарим нь хувь хүний танин мэдэхүй, зан чанарт төвлөрөх бол нөгөө хэсэг нь хөгжлийн болон орчны хүчин зүйлсийг онцолдог ч гүйцэтгэлийн нөхцөл, нийгэм-соёлын нөлөөг бүрэн хамарч чаддаггүй байна. Сүүлийн үеийн судалгаанд МРА-г зөвхөн сөрөг үзэгдэл бус, тодорхой нөхцөлд гүйцэтгэлийг дэмжих боломжтой, мөн гүйцэтгэлийн орчинд илрэх хэвийн сэтгэл зүйн хариу урвал хэмээн ойлгох хандлага нэмэгдэж байна. Гэвч энэхүү ойлголтыг бодит сургалтын орчинд хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх нь цаашид нарийвчилсан судалгаа шаардсан хэвээр байна. Иймд МРА-г тайлбарлахад онолын болон арга зүйн хувьд нэгдсэн, олон түвшний хандлага шаардлагатай бөгөөд соёл, боловсролын онцлогт суурилсан судалгааг цаашид өргөжүүлэх хэрэгцээ байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд хөгжимдөх үеийн түгшүүр буюу МРА-ийн тайлбар нь Уилсоны 1997 онд дэвшүүлсэн хувь хүний зан чанарт чиглэсэн анхдагч загвараас эхлэн Кеннийн 2011 онд боловсруулсан хөгжлийн болон клиникийн хандлага, Папагеорги нарын 2007 онд санал болгосон нийгэм-боловсролын цогц загвар, Слобода, Лемэний 2002 онд хийсэн дасан зохицлын судалгаа дамжин өнөөгийн нейробиологийн болон интервенцийн судалгаа хүртэл тодорхой хөгжлийн хандлагатайгаар өрнөж ирсэн байна. Орчин үеийн судалгаанд МРА-г зохицуулж болох сэтгэл зүйн төлөв гэж үзэх хандлага давамгайлж байгаа нь хөгжмийн боловсролын практикт шинэ чиглэл нээж өгч байна.

Иймд МРА-г орчин, хөгжмийн боловсролын тогтолцоо, нийгэм-соёлын хүчин зүйлстэй уялдсан цогц үзэгдэл гэж авч үзэх нь онолын болон практик ач холбогдолтой бөгөөд цаашид монголын хөгжмийн боловсролын орчинд уг асуудлыг эмпирик судалгааны түвшинд системтэй авч үзэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- Fernholz, I., et al. 2019. "Prevalence of music performance anxiety: A systematic review." *Psychology of Music* 47(6): 832–849.
- Fishbein, M., et al. 1988. "Stage fright prevalence among musicians." *Journal of Research in Music Education* 36(3): 167–176.
- Herman, P., Clark, D. 2023. "Redefining music performance anxiety: A normative perspective." *Frontiers in Psychology* 14: 101-112.

- Kenny, D. T. 2011. *The psychology of music performance anxiety*. Oxford: Oxford University Press.
- Papageorgi, I., Hallam, S., Welch, G. 2007. "A social-educational approach to performance anxiety in young musicians." *Psychology of Music* 35(3): 399–418.
- Salmon, P. 1990. "Music performance anxiety: A review of the literature." *Australian Journal of Music Education* 1: 3–10.
- Sloboda, J., Lehmann, A. 1997–2010. "Professional development and adaptation in music performance." *Music Education Research* 4(1): 1–12.